



154

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

СУРГАЛТ СЕМИНАР ЯВУУЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

Нэг. Нийслэлийн хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг шалгах ажлыг эрчимжүүлэх, багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах аргачлал” сэдэвт сургалт, семинарыг 2008 оны 09 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

Хоёр. Сургалт, семинарын төсөв, хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


Гурав. Сургалт, семинарт шаардагдах 238.000 /хоёр зуун гучин найман мянга/ төгрөгийг арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг мэргэжилтэн /О.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.



Ж.ГАНБОЛД

НБТСХ-ны даргын 2008 оны 09 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар тушаалын хавсралт



СУРГАЛТ, СЕМИНАР ЯВУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Багшийн хөлс: /2 хоног х 16 цаг х 4000 төг/	128.000
2.	Заал талбайн хөлс:	30.000
3.	Бичиг хэргийн зардал:	10.000
4.	Гарын авлага, сурталчилгааны зардал:	50.000
5.	Видео бичлэг, зураг, хальс угаах зардал:	20.000
НИЙТ ДҮН:		238.000